

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Kahilingan sa panalangin para sa CAMENA

Ang mga kababaihan sa Sentral Asya ay nagtalaga ng kanila ng mga sarili sa kanilang pamilya sa pamamagitan ng pag-alaga ng mga anak at pagpapanatili ng relasyon sa pamilya, subalit nahaharap pa rin sila sa maraming hamon katulad ng kawalan ng hanapbuhay, taksil na asawa, at asawang na kikipagrelasyon sa maraming babae, kasama na rin ang kahungkagan sa espiritu. Ang grupo ng Women of Hope sa Sentral Asya ay nagmimimistryo sa pamamagitan ng iba't ibang digital platforms- tulad ng radyo, YouTube, Instagram, at TikTok—nagdadala ng mensahe ng pag-asa at kagalingan gamit ang kanilang katutubong wika, na may mga awit pag-samba, upang magdala ng kaaliwan at tapang sa mga kababaihan. Kahit sa malupit na kapaligiran, nagpapasalamat kami na maaari naming ipahayag ang pangalan ni Jesu-Cristo, at kami ay naglilingkod na umaasa na may positibong pagbabagong magaganap mula sa pag-ibig at pag-asa galing sa Diyos na magdadala sa mga kababaihan, sa kanilang pamilya at sa buong komunidad ng rehiyong ito ng mas maganda, maayos at matagumpay na buhay.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Эзэн минь, Израильд TWR Women of Hope багийг байгуулж, тэдэнд Таны зүрх, төлөвлөгөө, нөөц болон бүтээлч сэтгэлгээг өгөөч. (1 Коринт 3:9-11)

2. Эзэн минь, Ойрх Дорнодын тогтворгүй байдалд Таны амар тайвныг тогтоогооч. Тэндхийн эмэгтэйчүүд өөрчлөгдөшгүй Бурханы амлалтуудад найдвар, хүч, итгэл, тэвчээрийг олох болтугай. (Иохан 16:33)

3. Умард Африкт хавчлага дор байгаа хүмүүс манай Кабиле багийн үйлчлэлээр Есүс Христ доторх найдвар, итгэлийн баталгаа олох болтугай. (Ром 8:37-39)

4. Эзэн минь, Турк дэх сая сая дүрвэгсэд амьдралын сорилттой тулгарахдаа Таныг мэдэж, Таныг эрж хайх болтугай. (Дуулал 54:4)

5. Киприйн эмэгтэйчүүд Есүсийг зөвхөн түүхэн хүн эсвэл сайн бошиглогч бус, харин Бурхан гэдгийг ойлгож, Түүнд найдвараа тавих болтугай. (Иохан 1:1)

6. Оросод ажилладаг нөхрүүдийнхөө хамаатнууд болон хүүхдүүдээ ганцаараа асрах болсон Тажикистаны эмэгтэйчүүдийг Бурхан минь хүчирхэгжүүлж, ачааг нь үүрэгч нь Та болооч. (1 Петр 5:7)

7. Эзэн минь, Ойрх Дорнодын сонсогчдын зүрх Таны үнэн рүү нээлттэй байж, TWR Women of Hope хөтөлбөрийг сонсоход Таны үнэн тэдний зүрхэнд хүрэх болтугай. (Дуулал 25:5)

8. Иранд ажил хийдэг эмэгтэйчүүд, ялангуяа ганц бие эхчүүд эдийн засгийн бэрхшээлд илүүтэй нэрвэгдэж байна. Тэдэнд практик дэмжлэг болон Есүсээс ирэх итгэл найдварыг өгөх болтугай. (2 Коринт 9:8)

9. Аав аа, Умард Африк дахь Кабиле багийн гишүүд болон тэдний гэр бүлд хамгаалалт, эдгэрэл өгөөч. (Гэтлэл 15:26)

10. Ойрх Дорнодын өсвөр үеийнхэн ирээдүйнхээ тухай тодорхойгүй байдалтай тэмцэж байх үедээ Таныг бат бөх сууриа болгох болтугай. (Исаиа 28:16)

11. Бурхан минь, Казахстаны орон гэргүй болсон, ганцаараа хоцорсон эмэгтэйчүүдэд тусламждэмжлэг, орон байр өгөөч. (Исаиа 58:7)

12. Эзэн минь, Туркийн баг хцүү, хүнд нөхцөлд байгаа эмэгтэйчүүдэд үйлчлэхэд нь бэлтгэж, хүч чадал, мэргэн ухаан өгөөч. (Иов 12:13)

13. Аав аа, Ойрх Дорнод дахь манай хариу өгөх багуудыг сонсогчидтой харилцахад чиглүүлж, Ариун Сүнсээрээ эдгэрэх, дагалдагч болох гүн гүнзгий итгэлийг өгөөч. (Ром 10:17)

14. Эзэн минь, Умард Африкийн хамгийн бага хүрсэн бүлгүүдийн нэг болох Амазиг ард түмний зүрхийг нээж, Таны үнэн, авралыг хүлээн авах болтугай. (Ефес 3:14-19)



15. Эзэн минь, Израильд орос хэлээр ярьдаг эмэгтэйчүүдэд үйлчлэх манай шинэ баг шаардлагатай бүх медиа сувгуудаар амжилттай үйлчлэлээ эхлүүлэхэд туслах болтугай. (Сургаалт үгс 16:3)

16. Аав аа, Ойрх Дорнод, Африк зэрэг улсуудаас Кипрт ирж буй эмэгтэйчүүд харанхуйн дунд Есүсийг гэрэл болгон таних болтугай. (Иохан 8:12)

17. Эзэн минь, Ойрх Дорнод дахь манай араб багийн бэлтгэж буй шинэ гурван цувралын цөөнгүй ангид орсон мессеж бүр үнэн, урам зориг, өөрчлөлт авчирч чаддаг байх болтугай. (Ром 12:2)

18. Туркт залуучуудын ажилгүйдэл өндөр байгаа энэ үед анхны ажлын алхамаа хийж буй залуу эмэгтэйчүүд ирээдүйнхээ найдвар, итгэлийг Танд өгөх болтугай. (Иеремиа 29:11)

19. Эзэн минь, Киргизстан дахь удирдагчдад хамтран боловсролын тогтолцоог сайжруулах мэргэн ухаан, урам зориг өгөөч. (Сургаалт үгс 2:6)

20. Эзэн минь, хавчлага, дарлалаас зугтаж, цөллөгт илгээгдэхээс үргэлж айж байгаа Ойрх Дорнодын дүрвэгсдийг Өөртөө дуудаж, Есүс доторх найдвараар дүүргээч. (Ром 15:13)

21. Эзэн минь, Умард Африкт сүмүүдийг хүчээр хаасан газарт амьдарч, үйлчилж буй Кабиле багийг хүчирхэгжүүлээч. (Ефес 6:10-18)

22. Эзэн минь, Туркменистанд хүнд нийгмийн болон гэр бүлийн дарамтад буй эмэгтэйчүүд Тантай харилцаатай болж, амьдралдаа жинхэнэ эрх чөлөөг олох болтугай. (1 Тимот 2:3-4)

23. Бурхан минь, байгалийн гамшиг, газар хөдлөлөөс дахин айж буй Туркийн эмэгтэйчүүд өөрчлөгдөшгүй амар тайвныг Таны оршихуйд эдлэх болтугай. (Исаиа 26:3)

24. Эзэн минь, Ойрх Дорнодын эмэгтэйчүүдийн амсдаг соёлын худал, ичгүүр, голох байдлыг халж, Таны охид өөрсдийгөө Таны нүдээр харж, үнэлж, хайрладаг болохыг мэддэг болох болтугай. (Эхлэл 1:27)

25. Эзэн минь, Узбекистан, Каракалпакстанд амьдарч буй эмэгтэйчүүд Women of Hope хөтөлбөрөөр дамжуулан Тантай, гэр бүлтэйгээ, ажлаа тэнцвэртэй байдлын харилцааг олох болтугай. (Матай 6:33)

26. Бурхан минь, бэлгийн хүчирхийлэлд өртөж, сэтгэл зүрх нь шархалсан Туркийн Сарад эдгэрэл, амар тайван, гэрэлтэй ирээдүй өгөөч. Манай багийн хайр, дэмжлэг түүнийг хүрээлэхэд туслаач. (Дуулал 147:3)

27. Бурхан минь, Ойрх Дорнодод нийгэмдээ гэрэл, найдвар, үнэн авчрах сүнслэгээр боловсорсон, зоригтой, энэрэнгүй шинэ эмэгтэй удирдагчдыг босгооч. (Матай 5:14-16)

28. Аав аа, дэлхий даяарх зөрчил, дайн дунд буй үндэстнүүдийн хооронд урт хугацааны энх тайвныг өгөөч. (Матай 5:9)

29. Аав аа, Ойрх Дорнодын эмэгтэйчүүдэд илүү их хувийн эрх чөлөө өгч, Танд байгаа жинхэнэ эрх чөлөөг мэдрэх болтугай. (Иохан 8:36)

30. Эзэн минь, Туркийн Хейлид өршөөл, найдвар, хүч өгөөч. Тэр шоронд орвол хүүхдээ алдахаас айж байна. Тэр Таныг харж, Танаас хүч авах болтугай. (Дуулал 140:12)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. Баянхонгорт шинээр эхэлсэн эмэгтэйчүүдийн залбирлын бүлгийн төлөө. Тэд тогтмол цуглаж, өсөж хөгжихөд нь Бурхан туслахын төлөө, уг бүлгийг удирдаж, чиглүүлж буй Сүүгий эгчид Бурхан мэргэн ухаан, сүнслэг ялган таних чадвар өгөхийн төлөө.
2. Ховдын залбирлын бүлгийн удирдагч Золоог Бурхан бүрэн эдгээж, хүч чадал өгч, удахгүй өвдөлтгүй алхахын төлөө.

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.